



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/392

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед
жирэмсэн, төрөх, төрсний дараа үзүүлэх
тусламж, үйлчилгээний түр зааврыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед жирэмсэн, төрөх, төрсний дараа үзүүлэх тусламж, үйлчилгээний шинэчилсэн түр заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй, чанартай үзүүлэхийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II (А.Эрдэнэтуяа), Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж) болон Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх шатны эмнэлэг, амаржих газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.


3. Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), эмнэлэг хүртэлх болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй үзүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг удирдаж, шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх шатны эмнэлэг, амаржих газрын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйгээр удирдаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох), Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл /Б.Цэдмаа/, холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, эмнэлзүйн зөвлөх багт тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/562 тоот тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

21-Tushaal-A

141211633

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06
дугаар сарын 21 -ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)- ЫН ҮЕД ЖИРЭМСЭН, ТӨРӨХ, ТӨРСӨНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Одоогийн нөхцөл байдал

Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын нийт 91,151 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс дотоодын халдвар 90,365 (УБ-75,721, орон нутаг-13026), зөөвөрлөгдсөн 553, эрүүл мэндийн салбарын 233 байна. (2021 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 11 цагийн байдлаар).

Сүүлийн үед Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол дархлаажуулалтад хамрагдаагүй иргэд, тэр дундаа жирэмсэн эхчүүдийн дунд хурдацтай тархаж эхийн өвчлөл, эндэгдлийн шинэ шалтгаан болоод байна. 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр (tandalt.gerege.mn)-ийн мэдээллээр Улсын хэмжээнд нийтдээ 1594 жирэмсэн эмэгтэй коронавируст халдвар (КОВИД-19) авсан бөгөөд тэдгээрийн 95.6 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 4.4 хувь нь орон нутагт оношлогдон эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдаж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн эмэгтэйчүүдийг насны бүлгээр нь авч үзвэл 25-37 насны (75-78 хувь), жирэмсний хугацаагаар нь авч үзвэл 20-36 долоо хоногтой (36-38 хувь) тус тус эзэлж байна. Коронавируст халдвар (КОВИД-19) жирэмсэн эмэгтэйчүүдэд илрэхдээ ханиалгах шинж тэмдэг- 19 хувьд, толгой өвдөх-19 хувьд, амтлах, үнэрлэх мэдрэмж алдагдах-18 хувьд, хоолой хөндүүрлэх- 13 хувьд, халуурах- 11 хувьд, хамар битүүрэх шинж тэмдэг- 8 хувьд нь тус тус илэрсэн байна. Монгол Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүндрэлийн улмаас жирэмсэн, төрсний дараа эх эндсэн тохиолдол ч гарлаа.

Иймд коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед жирэмсэн, төрөх, төрсний дараа үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид онцгойлон анхаарах шаардлагын үндсэн дээр түр зааврыг шинэчлэн боловсруулж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ)-ын эмнэлзүйн удирдамжид тэмдэглэснээр жирэмсэн ба төрсөн эхчүүдэд КОВИД-19 өвчний үед нийтлэг илэрдэг (халуурах, амьсгал давчдах, булчин өвдөх г.м.) эмнэлзүйн шинж жирэмсэн бус эмэгтэйчүүдтэй харьцуулахад (0.28, 95% CI 0.13 -0.62; 4 судалгаа; 462 051 эмэгтэй) бага байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай эхээс төрсөн нийт нярайн гуравны нэг нь нярайн эрчимт эмчилгээний тасагт (33%) эмчлэгдсэн ба ямар нэгэн заалтаар нярайн эрчимт эмчилгээний тасагт (NICU) эмчлэгдэх эрсдэл (OR = 4.89, 95% CI 1.87-12.81; 10 судалгаа, нярайн 5873) Коронавируст халдвар (КОВИД-19)-гүй эхчүүдээс төрсөн хүүхдүүдтэй харьцуулбал нэмэгдэж байна.

SARS-CoV-2 жирэмсэний явцад эхээс урагт, эсвэл төрөх явцад дамжих боломжтой байж болох ч өнөөдрийг хүртэл нярайд бүртгэгдсэн халдварын ихэнх нь төрсний дараах үед халдварлагдсан байх магадлалтай байна.

Халдвартай болон халдваргүй жирэмсэн эмэгтэйчүүдийг харьцуулахад дутуу төрөлт (OR1.47, 95% CI 1.14-1.90; 18 судалгаа; 8549 эмэгтэйчүүд) илүү тохиолдож байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай 19600 эхэд хийсэн судалгаагаар (АНУ) жирэмсэн биш эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрчимт эмчилгээний тасагт хэвтэх, зохиомол амьсгалуулалт хийх нь 3 дахин, нас баралт 2 дахин их байна гэж мэдээлэгджээ.

Хоёр. Эмнэлзүйн зөвлөмж

Жич: Энэхүү зааврыг сүүлийн 6 сарын хугацаанд ДЭМБ болон бусад мэргэжлийн холбоо, нийгэмлэгүүдээс гаргасан заавар зөвлөмжийг үндэслэн боловсруулав.

2.1. Халдварын тархалт, хавьтлыг эрт илрүүлэх
ДЭМБ-ын зөвлөмж (2021-01-21)

Зөвлөмж 1

Коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан хүнтэй хавьтал болсон, асуумж бүхий жирэмсэн эмэгтэйчүүдийг шинж тэмдэггүй ч байсан халдвар дамжсан байх магадлалтай тул эрсдэлийг тооцож онцгой хяналтанд авч хянана.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн эмэгтэй, жирэмслэлтийг шийдвэрлүүлсэн эмэгтэйчүүд эмнэлзүйн хувьд хүндэвтэр, хүнд байвал богино хугацаанд хүндрэх эрсдэлтэй, эх, ургийн амь насыг хамгаалах, яаралтай тусламж шаардагдах тул эмнэлэгт хэвтүүлж тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Санамж

1. Жирэмсэн эмэгтэйчүүдэд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын аюултай шинж илэрсэн, эх өөрөө ургийн хөдөлгөөнөө багассаныг ажигласан зэрэг зовиур илэрвэл эх, нярайд гарах шинжүүдийн талаар дэлгэрэнгүй зөвлөгөө өгнө. Үүнд:

1.1 Өвчний өвөрмөц шинжүүд, халдварын хүндрэлийн байдал эсвэл жирэмсэн үеийн аюултай шинжүүд (үтрээнээс цус эсвэл шингэн гарах, нүд бүрэлзэх, толгой хүчтэй өвдөх, бие сулрах эсвэл толгой эргэх, хэвлийгээр хүчтэй өвдөх, нүүр, сарвуу, хөл хавагнах, хоол эсвэл шингэн зүйл шингээхгүй болох, татах, амьсгалахад бэрхшээлтэй болох, ургийн хөдөлгөөн багасах зэрэг) гэх мэт бусад аюултай шинжүүд илэрвэл яаралтай тусламж авах хэрэгтэйг зөвлөнө. Төрөлтийн бэлтгэл болон хүндрэлийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчилж хэзээ, хаанаас тусламж авах мэдлэгтэй болгоно.

1.2 Өөрийгөө тусгаарлаж байгаа жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүд өөртөө тусламж үзүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Үүнд: Жирэмсний болон төрсний дараах үеийн эрүүл мэндийн байгууллагад хийгдэх ердийн товлолт үзлэгийг хойшлуулж үүний оронд жирэмсний болон төрсний дараах зөвлөгөө, тусламж, дагаж хяналт хийх зэргийг өрхөд суурилсан утсан харилцааны эсвэл телемедицин гэх мэт аргаар явуулна.

1.3 Үр хөндөлтийн үйлчилгээ шаардлагатай эмэгтэйчүүдийн хувьд жирэмсний 12 долоо хоногт багтаж эх барих, эмэгтэйчүүдийн эмчид хандах бөгөөд тухайн үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл авна. Мэргэжлийн эмч үйлчлүүлэгчийн биеийн байдал жирэмсний хугацааны талаарх мэдээлэлд үндэслэн “Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээ”-ний стандарт MNS 5488:2019, эрүүл мэндийн сайдын

тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Үр хөндөлтийн тусламж үйлчилгээ жирэмсний тодорхой хугацаагаар хязгаарлагддаг тул үр хөндөлтийн тусламжийг хойшлуулахгүй үзүүлэх нь хувь хүн аюултай үр хөндөлтийн үйлчилгээг сонгох эрсдлийг бууруулж, эхийн өвчлөл, эндэгдлээс сэргийлнэ.

2. ДЭМБ-ын жирэмсэн болон төрсний дараах үеийн эмчилгээний удирдамжид заасны дагуу эмэгтэйд эрүүл хүнс хэрэглэх, дасгал хөдөлгөөн хийх, өөртөө болон хүүхдэдээ бичил тэжээл хэрэглэх, тамхидалтаас сэргийлэх, архи болон бусад бодисууд хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө өгнө. Мөн жирэмсэн эмэгтэйчүүд жендерт суурилсан хүчирхийлэлд өртөж болзошгүй талаарх зөвлөгөө өгч, хүчирхийллийг илрүүлэх, үүнээс хэрхэн сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тусламж хаанаас авах талаар зөвлөгөө өгсөн байна.

Зөвлөмж 2.

Коронавируст халдвар (КОВИД-19) сэжигтэй, магадгүй эсвэл өвчтэй нь батлагдсан жирэмсэн эмэгтэйчүүд эх баригчийн, эх барихын, ургийн анагаах ухаан, мөн сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэгийг багтаасан, эх, нярайн хүндрэлүүдэд үзүүлэх тусламжийн бэлэн байдал бүхий эмэгтэй-төвтэй, хүндэтгэлтэй, ур чадвар бүхий тусламжинд очих бололцоотой байх ёстой.

Санамж:

1. Үйлчлүүлэгч эмэгтэйд-чиглэсэн, хүндэтгэлтэй ханддаг, мэргэжлийн ур чадвар бүхий тусламж гэдэг нь эмэгтэйчүүдийн нэр төр, хувийн нууцыг хадгалсан, аюулгүй, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолоос ангид, эрх чөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн, мэдээлэлд суурилсан сонголт хийх боломжтой, эмэгтэйчүүдийн төлөө зохион байгуулалттай, тусламж үйлчилгээний цогц юм. Жирэмсэн эмэгтэй төрөлтийн явцад өөрийн сонгосон туслагчтайгаа хамт байх, төрлөгийн үеийн өвдөлт намдаалт хийгдсэн, төрлөгийн үед хөдөлгөөнтэй байж, төрөх үедээ өөрт эвтэйхэн байрлалаа сонгох зэргийг багтаасан байдаг.

2. Төрөх үеийн туслагчийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож болно. Туслагч коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй эсвэл халдвартай нь батлагдсан бол эмэгтэйтэй зөвшилцөж өөр, эрүүл туслагч сонгоно. Сонгогдсон төрөлтийн туслагчдад төрлөг, төрөлтийн явцад болон төрсний дараа эх, нярай эрүүл мэндийн байгууллагад байх үед хувийн хамгаалах хэрэгслүүдийг хэрхэн хэрэглэх талаар сургалт явуулж, байгууллага доторх хөдөлгөөнийг хязгаарлах, халдвар хамгаалал, хяналтын арга хэмжээ авах нь ямар их ач холбогдолтойг урьчилан тайлбарлаж өгсөн байна.

Зөвлөмж 3.

Эх барихын заалт болон эмэгтэйн сонголтонд үндэслэн хүн бүрт төрөлт явуулах тохиромжтой аюулгүй аргыг тогтооно. ДЭМБ төрөлт сэдээлт болон Кесар мэс заслыг зөвхөн эмнэлгийн заалттай үед болон эх, ургийн байдалд үндэслэн сонгохыг зөвлөмж болгодог. Коронавируст халдвар (КОВИД-19) авсан байх нь дангаараа Кесар мэс заслын заалт болохгүй.

Санамж:

1. Яаралтай төрүүлэх болон жирэмслэлтийг таслах шийдвэрийг жирэмсний хугацаа, эхийн биеийн байдал, ургийн амьдрах чадвар зэрэг олон хүчин зүйлүүдэд тулгуурлан гаргана.

2. Төрлөг, төрөлтийг хурдасгах (ж.нь: эрчимжүүлэлт, хярзан сэтлэлт, үйлдлийн тусламжтай төрүүлэх) үйлдлийг зөвхөн эмнэлгийн талаас заалттай үед болон эх, ургийн эмнэлзүйн байдалд үндэслэн хэрэглэнэ.

3. Эх, нялхсын эрүүл мэнд болон хооллолтыг сайн байлгахын тулд хүйг хожуу хавчихыг (төрснөөс 1 минутаас хойш) зөвлөмж болгодог. Коронавируст халдвар (КОВИД-19) цусаар дамжих эрсдэл бага байна. Иймд хүйг хожуу хавчих нь эхээс нярайд вирус дамжих магадлалыг нэмэгдүүлдэг гэсэн нотолгоо байхгүй. Хүй хавчихыг 1-3 минут хүлээх нь нярайн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй нь батлагдсан бөгөөд хүйг эрт таслахын давуу тал одоогоор нотлогдоогүй байна. Иймд хүйг эрт таслахыг зөвлөхгүй байна.

4. Коронавируст халдвар (КОВИД-19) сэжигтэй эсвэл батлагдсан, хөнгөн хэлбэрийн өвчинтэй жирэмсэн эмэгтэйчүүд төлөвлөсөн төрөлт сэдээлт эсвэл кесар мэс заслыг хойшлуулах талаар хүн тус бүрд тохирсон шийдвэр гаргах ёстой

Зөвлөмж 4.

Коронавируст халдвар (КОВИД-19) эдгэрсэн, эмчилгээ шаардлагагүй жирэмсэн эмэгтэйчүүдэд ердийн тусламж үзүүлдэг журмаараа жирэмсэн, төрөлт, төрсний дараах эсвэл үр хөндөлтийн дараах тусламжийг үзүүлнэ. Харин ямар нэг хүндрэл гарсан бол нэмэлт тусламж үзүүлнэ.

Санамж:

1. Коронавируст халдвар (КОВИД-19) халдвартай эсвэл эдгэрсэн бүх жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний явцад учирч болох эрсдэлтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдалтай хамааруулахгүй жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж болон үр хөндөлтийн цогц тусламж, үйлчилгээг хуулийн хүрээн дэх сонголт, үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэж үзүүлнэ.

Гурав. ЭХ БАРИХЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**1.1 Жирэмсэн эмэгтэйг халдвараас сэргийлэх**

Жирэмсний хяналтаар эмэгтэйчүүдийг эмнэлэгт хандах тоог цөөрүүлэхэд анхаарна.

- Нийгмийн харилцаанд хүн хоорондын зай барих, олон хүнтэй газраар явахгүй байх, эмнэлэгт ирэлтийн тоог цөөлөх, ердийн товлот үзлэгийн заримыг Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу цахимаар хийх
- Амны хаалт тогтмол зүүх
- Гараа зааврын дагуу тогтмол угаах
- Зөвхөн зайлшгүй шаардлагатай сорил, шинжилгээг хийх
- Хэт авиан хяналтыг цөөлөх /жирэмсэн хэвийн явцтай үед 3 удаа үзүүлэх заалттай, хамгийн чухал нь жирэмсний 18-20 долоо хоногтойд үзүүлнэ/.

- Хэвийн явцтай жирэмсний үед эмэгтэй болон түүний ар гэрийнхэнтэй сайн холбоо тогтоосноор тэдэнтэй хамтран үзлэгийн тоог цөөрүүлж хянаж болно. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06-р сарын 04-ний өдрийн А/318 тушаал “Жирэмсэн төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-д хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзэхээр заасан хэдий ч жирэмсний 12, 20, 28, 36 долоо хоногтойд хяналтанд зайлшгүй үзнэ (ДЭМБ)
- Жирэмсэн эмэгтэйг цахим үзлэгээр хянаж болно. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03 сарын 17-ны өдрийн А/133 тушаал “Коронавирусын халдварын үед жирэмснийг хянах цахим үзлэгийн журам”-ын дагуу хянана.
- Жирэмсэн эмэгтэйг вакцинжуулах . ЭМС-ын 2021 оны 05 сарын 28-ны өдрийн А/338 тоот “Коронавируст халдвар (Ковид 19) –ын эсрэг Комирнэти (BNT 162b2) вакцинаар дархлаажуулах тухай” тушаалыг мөрдөнө

3.2 Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн, жирэмслэлтээ шийдвэрлүүлээд удаагүй байгаа эмэгтэйчүүд, төрсөн эмэгтэйд үзүүлэх тусламж, эмчилгээ

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн эмэгтэйчүүд болон төрсний дараах эмэгтэйд илрүүлэлт, эрэмбэлэн ангилалт, эмнэлзүйн шинж, ангилал, оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээ, нэн хүндэрсэн тохиолдлын эрчимт эмчилгээ, коронавируст халдварын тохиолдлын хяналт, эмнэлгээс гаргах шалгуур зэргийг тогтоохдоо Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 18-ны өдрийн А/318 тоот тушаалаар батлагдсан “Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар”-ыг мөрдөнө (эмнэлзүйн заавар өөрчлөгдсөн үед тухайн зааврыг баримтална)

3.2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн болон төрсний дараах үед байгаа эмэгтэйг эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ.

3.2.2. Жирэмсэн эмэгтэй болгонд А. Б. В. Г бүлгээр өндөр эрсдлийг тогтооно. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүнд хэлбэрээр өвдөх илүү эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдэд

- Ахимаг насны жирэмсэн (≥ 35)
- Хавсарсан эмгэгтэй (АД ихдэлт, чихрийн шижин, зүрхний эмгэг г.м)
- БЖИ ≥ 25
- Жирэмсний хүндрэл (жирэмсний эрт үеийн хордлого, манас таталтын урьдал)
- Тамхи татдаг
- Сэтгэл санаа хямарсан, бухимдалтай зэрэг

3.2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдлыг зааварт заасан эмгэгүүдээс гадна жирэмсэн үеийн хүндрэл (манас таталтын урьдал, HELLP хам шинж, жирэмсэн үеийн ялтас эсийн цөөрөл), төрөх үеийн халууралт, хориоамнионит, төрсөний дараах үеийн умайн үрэвсэл, халдвар, үжил зэргээс ялган оношилно.

3.2.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн болон төрсний дараах үед хэвтэн эмчлүүлж байгаа эмэгтэйд шаардлагатай тохиолдолд эх барих, эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран халдварт, эрчимт эмчилгээ, ургийн анагаах ухаан, нярайн, сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг цогц байдлаар үзүүлнэ.

3.2.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн зааварт тусгагдсан **ерөнхий** эмчилгээг зааврын дагуу хийнэ.

3.2.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн **өвөрмөц** эмчилгээ болох SARS-CoV-2 вирусын эсрэг эм бэлдмэлийн хувьд:

- Ремдесивирийг жирэмсэн үед зааврын дагуу хэрэглэнэ.
- Фавипиравир (Авиган) -ыг жирэмсэн үед хэрэглэхгүй.
- Умифеновир (арбидол) бэлдмэлийг жирэмсний эхний 3 сар (12+6 долоо хоног)-ын дотор хэрэглэхгүй. Гэхдээ эхийн амь насыг аврах, эмнэлзүйн хувьд өөр эмчилгээний сонголтгүй тохиолдолд эмч нарын шийдвэрт үндэслэн, эмчийн хяналтанд болгоомжтой хэрэглэж болно.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг үр дүнтэй эмчилгээг жирэмсэн гэсэн шалтгаанаар хасаж болохгүй.
- Интерферон бета (тос, түрхлэг, лаа), реконвалесцент сийвэн, SARS-CoV-2 эсрэг иммуноглобулин зэрэг эмчилгээг хийж болно.

3.3 Төрөлт удирдах

3.3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эх барихын болон эх, ургийн талаас хүндрэлгүй тохиолдолд жирэмсэнг хугацаа гүйцээн тээлгэж төрүүлнэ. Эх, нярайд мэргэжлийн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой газар төрүүлнэ. Анхаарах нь:

- Коронавируст халдвар (КОВИД-19) нь жирэмсэнг таслах, хугацаанаас өмнө шийдэх заалт болгохгүй,
- Төрөх үеийн туслагч байлгахыг зөвшөөрнө /халдварын сэргийлэлт хяналтын сургалтанд хамрагдсан байх/,
- Төрлөгийн үеийн өвдөлт намдаалт хийхийг зөвшөөрнө
- Шаардлагагүй арга хэмжээ, ажилбараас зайлсхийх (амниотоми, төрөлт эрчимжүүлэх)
- Нярайн тусламжийн бэлэн байдал хангагдсан байна.
- **Төрөлт удирдахад ДЭМБ-ын “Жирэмсэн, төрлөгийн хүндрэлийг удирдах арга зүй” (ЭМС-ын 2012 оны 02-р сарын 06. 42 тушаал) удирдамжийг мөрдөнө.**

3.3.2. Төлөвлөгөөт болон яаралтай Кесар мэс заслаар төрүүлэх тохиолдолд мэргэжлийн баг, нөхцөл бүрдүүлж мэс засал хийнэ. *ЭМС-ын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 205 тоот тушаал, ЭМС-ын 2019 оны 518 тоот тушаал, “Кесар мэс заслаар төрүүлэх” зааврыг мөрдөнө.*

- Кесар мэс засал хийхээр бол биеийн байдал, хүндийн зэргээс хамааруулж мэдээгүйжүүлгийн аргыг сонгоно. Амьсгалын дутагдалтай цаашид зохиомол амьсгал үргэлжлүүлэх заалттай тохиолдолд ерөнхий мэдээгүйжүүлэг хийнэ.

3.3.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нэн хүнд үед хөнгөвчлөх зорилгоор эсвэл ургийн талаас заалт гарвал жирэмсний ≥ 26 долоо хоногтойд жирэмсэнг шийднэ.

3.3.4. Ковид 19 халдварын нэн хүнд үед нас барах үеийн болон сэхээн амилуулалт тойрны (перимортем) Кесар мэс засал хийж болно

3.4. Дутуу төрөлтийн үеийн тусламж

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай жирэмсэн эмэгтэй нь уг өвчний хүндрэл (уушгины хатгалгаа, хүчилтөрөгчийн дутагдал, нэн хүнд зэрэг) эсвэл эх барихын хүндрэл (манас таталтын хүнд хэлбэр, HELLP хамшинж, ихсийн цус алдалт) эсвэл ургийн байдал (ургийн өсөлтийн саатал, олон урагт жирэмсний үеийн эмгэг, ургийн дистресс)-аас шалтгаалж жирэмсний 37 долоо хоногоос өмнө төрүүлэх шаардлага гарч болох тул дутуу төрөлтийн үед үзүүлдэг тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Дутуу төрөлтийн үед үзүүлэх тусламж:

Эмчилгээ	Зорилго	Хэрэглэх арга	Жирэмсний хугацаа
Стероид	Ургийн уушгины хөгжлийг дэмжих	Дексаметазоныг 6 мг-аар 12 цагаар 4 тунг булчинд тарина	Жирэмсний 24-34 долоо хоногтойд
Хүхэр хүчлийн магни	Ургийн мэдрэл хамгаалах эмчилгээ	Цохилтын тунг 4 гр-аар 20 минутын турш судсаар Барих тунг 1 гр/цаг судсанд дуслаар төрөх хүртэл эсвэл 24 цагийн турш.	Жирэмсний 24-32 долоо хоногтойд, төрөлт 24 цагийн дотор явагдах тохиолдолд
Нифедипин (кальцын сувгийн хориглогч)	Умайн агчил бууруулах	10 мг 20 минутын зайтай 3 тун ууна. Цаашид 4-6 цагийн зайтай 20 мг ууна.	<34 долоо хоногтойд
Индометацин (Простагландин ы нийлэгжилтийг саатуулагч)	Умайн агчил бууруулах	Эхний тун 50-100 мг ууна. Барих тун: 25 мг-аар 4 - 6 цаг тутам хэрэглэнэ -48 цаг л хэрэглэнэ	Жирэмсний <31+6 долоо хоногтойд өгнө

3.5. Төрсний дараах тусламж

- Нярайд эрт үеийн нэн шаардлагатай тусламж үзүүлнэ.
- Эх, нярайг хамт байлгана.
- Хүүхдийг хөхний сүүгээр хооллоно.
- Халдвар хамгааллын дэглэм сахина (Нярайн тусламж үйлчилгээний талаар зааварт заагдсан байгаа)
- Төрсөн эхийг эмнэлгээс гаргахдаа эх барихын талаас хүндрэлгүй бол зааварт заасан шалгуурыг баримтална.
- Төрсний дараа эх, нярайн хяналтыг заавар, удирдамжийн дагуу хийнэ. Цахим үзлэгээр хийж болно.